

Азтай дэд тэмдэгт мөр

Петя азтай тоонд дуртай. Таны мэдэж байгаачлан азтай тоо гэдэг нь бичлэгтээ зөвхөн 4 болон 7 цифр агуулдаг тоо юм. Жишээ нь 47, 744, 4 тоонууд нь азтай тоо бол 5, 17, 467 тоонууд азтай тоо биш юм.

Нэгэн өдөр Петя зөвхөн цифрүүдээс бүтэх тэмдэгт мөр хүлээн авчээ. Тэрээр дараах гурван нөхцлийг хангах тэмдэгт мөрийг олохыг хүсчээ.

- Тэгээр эхлээгүй азтай тоо
- Хоосон биш
- s тэмдэгт мөрөнд хамгийн олон удаа агуулагдсан дэд тэмдэгт мөр

Дээрх гурван нөхцлийг хангах бүх тэмдэгт мөрүүдээс цагаан толгойн дарааллаар хамгийн багыг нь олно уу.

Input

Хоосон биш, урт нь хамгийн багадаа 1, хамгийн ихдээ 50 байх зөвхөн цифр агуулсан s тэмдэг мөр өгөгдөнө. Оролт тэгээр эхэлж болно.

Output

Хэрэв дээрх нөхцлүүдийг хангах тэмдэгт мөр олдохгүй бол "-1" гэж гарга. Эсрэг тохиолдолд бодлогын шийдийг хэвлэнэ.

Example

Input 1:

047

Output 1:

4

Input 2:

16

Output 2:

-1

Input 3:

472747

Output 3:

7